



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/82/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Булган хот 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Anhbayrd@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enhtsoodol@audit.gov.mn</p> <p>Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: Suvdaaa@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа	18
4.2 Албан шаардлага	18
4.3 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нийцлийн аудит
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 210

танай _____ ны № _____ т

ТЭШИГ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Ц.АЛТАНТУЯА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бараа материалын тайланг Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтын гуравт заасны дагуу НХМаягт БМ-9 маягтаар тайлагнаагүйгээс бараа материалын тодруулга тайлан нярвын тайлан 20,151,500.00 /хорин сая нэг зуун тавин нэгэн мянга таван зуу/ төгрөгийн зөрүүтэй тайлагнасан, 2020 оны санхүүгийн тайлангаар сөрөг дүгнэлт авсан зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.4-т заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв болон тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/bichighereg/2022A4toot

006020985

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	48,137,450.22	299,724,897.92
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	17,951,184.46
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	17,951,184.46
31120	Төрийн сангийн харилцах		13,797,093.46
31130	Нэмэлт санхүүжилт		4,154,091.00
33	АВЛАГА	907,228.38	163,997,235.38
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	84,030.00	50,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	130,230.00	162,139,030.00
335	Бусад авлага	692,968.38	1,808,205.38
3351	Байгууллагаас авах авлага	-	1,115,237.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	692,968.38	692,968.38
35	БАРАА МАТЕРИАЛ	47,230,221.84	117,776,478.08
351	Түүхий эд материал	15,413,285.80	55,723,757.54
35110	Тусгай зориулалттай материал	5,985,107.80	-
35130	Эм боох материал	9,428,178.00	55,723,757.54
354	Хангамжийн материал	31,816,936.04	62,052,720.54
35410	Бичиг хэргийн материал	662,100.00	3,818,360.00
35420	Аж ахуйн материал	26,568,360.34	51,588,870.34
35430	Сэлбэг хэрэгсэл	1,663,100.00	-
35440	Түлш, шатах тослох материал	126,600.00	-
35450	Барилгын засварын материал	-	4,466,000.00
35460	Хүнсний материал	2,796,775.70	2,179,490.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	419,293,724.47	430,477,888.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	419,293,724.47	430,477,888.97
392	Биет хөрөнгө	404,242,924.47	414,077,088.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	258,120,338.76	258,120,338.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	(38,920,601.09)	(58,060,501.73)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	219,662,468.00	219,662,468.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(69,383,035.15)	(95,660,575.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	56,663,857.86	126,574,281.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	(25,342,426.87)	(48,600,853.16)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,937,400.00	17,546,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,495,077.04)	(5,692,469.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	187,500.00
393	Биет бус хөрөнгө	15,050,800.00	16,400,800.00
39301	Програм хангамж	-	1,350,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	15,050,800.00	15,050,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	467,431,174.69	730,202,786.89
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	4,691,629.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	4,691,629.00
413	Өглөг	-	4,691,629.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	4,091,729.00
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	-	90,000.00

4136	Бусад өглөг	-	509,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	377,900.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	132,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	467,431,174.69	725,511,157.89
51	Засгийн газрын хувь оролцоо	467,431,174.69	725,511,157.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	244,527,471.75	244,527,471.75
512	Хуримтлагдсан үр дүн	69,826,191.59	327,906,174.79
51210	Өмнөх үеийн үр дүн	69,826,191.59	69,826,191.59
51220	Тайлант үеийн үр дүн	-	258,079,983.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	153,077,511.35	153,077,511.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	467,431,174.69	730,202,786.89

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	691,847,882.13	1,266,743,784.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	206,992,772.13	348,871,520.03
120	Нийтлэг татварын бус орлого	203,445,882.13	348,871,520.03
120001	Хувьцааны ногдол ашиг	4,931,430.95	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,775,320.00	158,647.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,775,320.00	-
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө	167,541,925.00	50,120,115.49
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал	13,197,206.18	298,592,757.54
122	Тусламжийн орлого	3,546,890.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	3,546,890.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	484,855,110.00	917,872,264.85
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	398,559,200.00	472,470,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	398,559,200.00	472,470,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,733,100.00	381,310,097.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	400,000.00	7,070,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,262,500.00	371,255,097.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	70,600.00	2,985,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	43,591,000.00	45,096,207.85
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	43,591,000.00	45,096,207.85
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	20,971,810.00	18,995,260.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20,971,810.00	18,995,260.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	533,096,099.28	1,007,626,977.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	533,096,099.28	1,007,626,977.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	531,991,359.01	938,536,977.88

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		
210101	Үндсэн цалин	321,504,131.68	362,489,158.00
210102	Нэмэгдэл	213,665,714.74	239,400,167.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	86,771,491.94	95,671,766.00
210104	Урамшуулал	-	4,692,540.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,066,925.00	22,724,685.00
210201	Тэтгэврийн даатгал	42,719,500.00	46,780,172.54
210202	Тэтгэмжийн даатгал	30,340,800.00	33,743,987.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,885,500.00	3,352,697.03
210204	Ажилгүйдлийн даатгал	2,334,600.00	2,651,936.98
210205	Эрүүл мэндийн даатгал	829,800.00	628,952.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,328,800.00	6,402,598.86
210301	Гэрэл, цахилгаан	41,222,541.05	42,710,657.85
210302	Түлш, халаалт	2,359,611.00	2,997,810.00
210303	Цэвэр, бохир ус	36,361,786.00	34,968,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,501,144.05	4,744,847.85
210401	Бичиг хэрэг	24,170,019.00	39,531,367.80
210402	Тээвэр, шатахуун	1,504,600.00	1,835,540.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,268,720.00	23,139,230.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,463,555.00	1,486,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,440,894.00	4,030,590.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,492,250.00	150,000.00
210408	Бараа материал акталсны зардал	-	2,904,500.00
2105	Нормативт зардал	-	5,985,107.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,078,765.78	343,611,147.50
210502	Хоол, хүнс	46,276,137.28	326,192,368.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,685,028.50	16,842,779.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	117,600.00	576,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,484,300.00	3,409,650.00
210604	Урсгал засвар	462,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	3,022,300.00	3,409,650.00
210702	Дотоод албан томилолт	1,354,000.00	2,618,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,354,000.00	2,618,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	587,950.00	819,517.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	155,950.00	629,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	432,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	81,675.00
210807	Газрын төлбөр	-	92,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	15,192.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,870,151.50	96,567,307.19
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,417,592.00	23,493,580.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,452,559.50	73,073,727.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,104,740.27	69,090,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000,000.00	69,090,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	35,200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,000,000.00	33,890,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,951.32	-
		57,951.32	-

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	46,788.95	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,788.95	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	158,751,782.85	259,116,807.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	26,190,584.78	1,036,823.80
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	55,200.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(26,190,584.78)	(1,036,823.80)
5	НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	132,561,198.07	258,079,983.20

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,527,471.75	153,829,101.35	(55,063,475.53)		343,293,097.57
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	751,590.00		751,590.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	244,527,471.75	153,829,101.35	(54,311,885.53)	-	344,044,687.57
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(751,590.00)	-		(751,590.00)
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	124,138,077.12		124,138,077.12
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,527,471.75	153,077,511.35	69,826,191.59	-	467,431,174.69
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	244,527,471.75	153,077,511.35	69,826,191.59	-	467,431,174.69
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	244,527,471.75	153,077,511.35	69,826,191.59	-	467,431,174.69
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	258,079,983.20		258,079,983.20
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,527,471.75	153,077,511.35	327,906,174.79	-	725,511,157.89

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	492,922,350.00	756,112,111.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,033,620.00	158,647.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	158,647.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	158,647.00
122	Тусламжийн орлого	4,033,620.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	4,033,620.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	488,888,730.00	755,953,464.85
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	398,559,200.00	472,470,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	398,559,200.00	472,470,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,733,100.00	219,391,297.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	400,000.00	7,070,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,262,500.00	209,336,297.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	70,600.00	2,985,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	43,591,000.00	45,096,207.85
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	43,591,000.00	45,096,207.85
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	25,005,430.00	18,995,260.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	25,005,430.00	18,995,260.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	486,490,730.00	716,835,213.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	486,490,730.00	716,835,213.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	485,055,759.73	633,896,327.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	321,574,483.68	362,489,158.00
210101	Үндсэн цалин	216,147,251.74	239,400,167.00
210102	Нэмэгдэл	84,326,276.94	95,671,766.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	4,692,540.00
210104	Урамшуулал	21,100,955.00	22,724,685.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,719,500.00	46,746,142.54
210201	Тэтгэврийн даатгал	30,061,900.00	33,743,987.33
210202	Тэтгэмжийн даатгал	3,164,400.00	3,352,697.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,531,500.00	2,651,936.98
210204	Ажилгүйдлийн даатгал	632,900.00	628,952.34
210205	Эрүүл мэндийн даатгал	6,328,800.00	6,368,568.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,222,541.05	42,710,657.85
210301	Гэрэл, цахилгаан	2,359,611.00	2,997,810.00
210302	Түлш, халаалт	36,361,786.00	34,968,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,501,144.05	4,744,847.85

2104	Хангамж, бараа материалын зардал	24,462,625.00	34,688,567.00
210401	Бичиг хэрэг	1,469,800.00	4,955,800.00
210402	Тээвэр, шатахуун	17,395,320.00	24,127,867.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,486,355.00	1,486,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,621,900.00	2,622,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,489,250.00	1,496,000.00
2105	Нормативт зардал	45,079,168.00	112,072,395.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,021,542.00	93,014,620.00
210502	Хоол, хүнс	6,940,026.00	15,937,775.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,117,600.00	3,120,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,297,670.00	7,255,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	976,000.00	990,000.00
210604	Урсгал засвар	2,321,670.00	6,265,050.00
2107	Томилолт, зочны зардал	1,900,000.00	2,618,000.00
210702	Дотоод албан томилолт	1,900,000.00	2,618,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	602,950.00	1,449,517.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	170,950.00	1,259,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	92,750.00
210807	Газрын төлбөр	-	15,192.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,196,822.00	23,866,840.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,196,822.00	23,866,840.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,434,970.27	82,938,885.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,200,000.00	69,090,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	35,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	33,890,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	57,951.32	13,848,885.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,951.32	13,848,885.61
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	46,788.95	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,788.95	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	130,230.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	130,230.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,431,620.00	39,276,898.85
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,398,000.00	35,174,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,398,000.00	35,174,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,398,000.00	35,174,600.00
222001	Тоног төхөөрөмж	2,398,000.00	35,174,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,398,000.00)	(35,174,600.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	4,033,620.00	4,102,298.85
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	17,951,184.46
----	---	---	---------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	540618700.00	522923721.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	540618700.00	516075121.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	539618700.00	515085121.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	357265000.00	343330068.00
210101	Үндсэн цалин	223742400.00	220241077.00
210102	Нэмэгдэл	99869500.00	95671766.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6804000.00	4692540.00
210104	Урамшуулал	26849100.00	22724685.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48230800.00	45251773.54
210201	Тэтгэврийн даатгал	33940200.00	32249618.33
210202	Тэтгэмжийн даатгал	3572700.00	3352697.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	2858100.00	2651936.98
210204	Ажилгүйдлийн даатгал	714500.00	628952.34
210205	Эрүүл мэндийн даатгал	7145300.00	6368568.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41998000.00	41947157.85
210301	Гэрэл, цахилгаан	3000000.00	2997810.00
210302	Түлш, халаалт	36598000.00	34968000.00
210303	Цэвэр, бохир ус	2400000.00	3981347.85
2104	Хангамж, бараа материалын зардал	26386700.00	26370200.00
210401	Бичиг хэрэг	1770600.00	1759400.00
210402	Тээвэр, шатахуун	19006800.00	19005900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,486,800.00	1,486,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,622,500.00	2,622,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,496,000.00
2105	Нормативт зардал	42,240,000.00	41,856,475.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,800,000.00	30,798,700.00
210502	Хоол, хүнс	7,940,000.00	7,937,775.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,500,000.00	3,120,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,800,000.00	2,789,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	990,000.00
210604	Урсгал засвар	1,800,000.00	1,799,050.00
2107	Томилолт, зочны зардал	1,900,000.00	1,898,000.00
210702	Дотоод албан томилолт	1,900,000.00	1,898,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,445,000.00	1,449,517.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,260,000.00	1,259,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	116,000.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	146,500.00	92,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	-
210807	Газрын төлбөр	40,500.00	15,192.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	30,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,353,200.00	10,192,880.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,353,200.00	10,192,880.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	990,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	990,000.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	990,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	6,848,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	6,848,600.00
222001	Тоног төхөөрөмж	-	6,848,600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	540,618,700.00	536,562,168.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	472,470,700.00	472,470,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	472,470,700.00	472,470,700.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,148,000.00	45,096,208.00
132001	Орон нутгийн төсвөөс	45,148,000.00	45,096,208.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,000,000.00	18,995,260.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	23,000,000.00	18,995,260.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		13,797,093.46

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	215,237,206.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	210,198,206.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	142,098,206.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,159,090.00
210101	Үндсэн цалин	19,159,090.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,494,369.00
210201	Тэтгэврийн даатгал	1,494,369.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	763,500.00
210303	Цэвэр, бохир ус	763,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,318,367.00
210401	Бичиг хэрэг	3,196,400.00
210402	Тээвэр, шатахуун	5,121,967.00
2105	Нормативт зардал	70,215,920.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	62,215,920.00
210502	Хоол, хүнс	8,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,466,000.00
210604	Урсгал засвар	4,466,000.00
2107	Томилолт, зочны зардал	720,000.00
210702	Дотоод албан томилолт	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,960,960.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,960,960.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,100,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,100,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	35,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,900,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,039,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,039,000.00
222001	Тоног төхөөрөмж	5,039,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	219,391,297.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	219,391,297.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,070,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	209,336,297.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,985,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 14-өөс 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Сувдаа гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хэрэгжүүлсэн.

Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго нь Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгон, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг стандарт технологийн дагуу үзүүлж тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулж иргэдийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, мэдлэг хандлагыг нэмэгдүүлэхэд оршино

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг аймгийн Засаг даргын А/424 тоот захирамжаар 2020 онд батлуулж Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг тусгасан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 559,231.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,388.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлаар тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 262,771.6 мянган төгрөгөөр буюу 56.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан харилцах, авлага, эм боох материал, аж ахуйн материал, машин тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, тайлант үеийн үр дүнгийн болон үндсэн хөрөнгийн элэгдэл данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	17951.2	17951.2
Урьдчилж гарсан тооцоо	907.2	163997.2	163090.0
Бараа материал	47230.2	117776.5	70546.3
Үндсэн хөрөнгө	419293.7	430477.9	11184.2
Нийт хөрөнгө	467431.2	730202.8	262771.6
Өр төлбөр	0.0	4691.6	4691.6
Хуримтлагдсан үр дүн	467431.2	725511.2	258080.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	467431.2	730202.8	262771.6

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Төрийн сангийн харилцах 13,797.1 мянган төгрөгөөр өссөн,
- ЭМДС-аас авах авлага 162,008.8, тээвэр шатахууны авлага 1,115.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн,
- Эм боох материал ковид-19 цар тахал гарсантай холбоотойгоор 46,295.6 мянган төгрөгөөр өссөн;
- Машин тоног төхөөрөмж 69,910.4 мянган төгрөгөөр, тавилга эд хогшил 9.609.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн;
- Тайлант үеийн үр дүн 258,079.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Үндсэн хөрөнгө данс тайлант оны элэгдлийн зардлаас голлон шалтгаалж 68,675.9 мянган төгрөгөөр буурсан;

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	691,847.88	1,266,743.78	574,895.90	83.1%
11	Татварын орлого	-	-	-	
12	Татварын бус орлого	206,992.77	348,871.52	141,878.75	68.5%
120004	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	17,775.32	158.65	(17,616.67)	-99.1%
122	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	3,546.89	-	(3,546.89)	-100.0%
13	Тусламж, санхүүжилтийн орлого	484,855.11	917,872.26	433,017.15	89.3%
1310	Улсын төсвөөс санхүүжих	398,559.20	472,470.70	73,911.50	18.5%
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,733.10	381,310.10	359,577.00	1654.5%
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	43,591.00	45,096.21	1,505.21	3.5%
1330	Төсвийн захирагчаас	-	-	-	
1340	НДС-аас санхүүжих	20,971.81	18,995.26	(1,976.55)	-9.4%
14	Бусад эх үүсвэр	-	-	-	
2	Үйл ажиллагааны зардлын дүн	533,096.10	1,007,626.98	474,530.88	89.0%
21	Урсгал зардал	533,096.10	1,007,626.98	474,530.88	89.0%
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	531,991.36	938,536.98	406,545.62	76.4%
211	Хүү	-	-	-	
212	Татаас	-	-	-	
213	Урсгал шилжүүлэг	1,104.74	69,090.00	67,985.26	6154.0%
22	Хөрөнгийн зардал	-	-	-	
3	Үйл ажиллагааны үр дүн /3=1-2/	158,751.78	259,116.81	100,365.02	63.2%
145	Үйл ажиллагааны бус орлого	-	-	-	
225	Үйл ажиллагааны бус зардал	26,190.58	1,036.82	(25,153.76)	-96.0%
4	Үйл ажиллагааны бус үр дүн /4=145-225/	(26,190.58)	(1,036.82)	25,153.76	-96.0%
5	Нийт үр дүн /5=3+4/	132,561.20	258,079.98	125,518.79	94.7%

Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нэмэлт санхүүжилтийн орлого өмнөх оноос 359,577.0 мянган төгрөг буюу 16.5 дахин өссөн, тайлант онд нийт орлого 574,895.9 мянган төгрөгөөр буюу 83.1 хувиар өсөж үйл ажиллагааны зардал 474,530.9 мянган төгрөгөөр буюу 89.0 хувиар өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийг 540,618.7 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 540,618.7 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Сангийн яамнаас урсгал зардлыг 540,618.7 мянган төгрөгөөр баталж тодотголоор өөрчлөлт ороогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 472,470.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 45,148.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, ЭМДС-аас 23,000.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн дансаар улсын төсвөөс 742,470.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 45,096.2 мянган төгрөг, ЭМДС-аас 18,995.3 мянган төгрөг, нэмэлт дансаар Төрийн болон болог орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандав, тусламж 7,070.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 209,336.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд 2,985.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч нийт 738,160.9 мянган төгрөгийн зарцуулалт хийснээс үндсэн дансаар 522,923.7 мянган төгрөгийг зарцуулж 96.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 522,923.7 мянган төгрөг буюу 96.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 13,934.9 мянган төгрөг, ажил олгогчийн НДШ 2,979.0 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 4,010.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 1,995.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1,160.3 мянган төгрөгөөр тус тус дутуу, хөрөнгийн зардалд 6,848.6 мянган төгрөгийг зарцуулснаас шалтгаалсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулалт нь үйл ажиллагааны урсгал зардал 24,543.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	760,010.00	738,160.93	21,849.07	97.1%
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	412,510.20	400,357.18	12,153.02	97.1%
1.2	80109	ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	43,798.00	43,746.21	51.79	99.9%
1.3	80302	Нэг иргэнд ногдох нормативаар	267,501.80	257,867.54	9,634.26	96.4%
1.4	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	36,200.00	36,190.00	10.00	100.0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа үлдэх өртөггүй элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.

3.8 Аудитын гол асуудал

Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал болох бараа материалын тайланг Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтын гуравт заасны дагуу НХМаягт БМ-9-өөр тайлагнаагүйгээс бараа материалын тодруулга тайлан нярвын тайлан 20,151,500.00 төгрөгийн зөрүүтэй тайлагнасан, 2020 оны санхүүгийн тайлангаар сөрөг дүгнэлт авсан зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.4-т заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв болон тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан local.audit.mn цахим бүртгэлийн хүрээнд мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн 2021 онд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын нийт 1,659,810.8 мянган төгрөгийн 83 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас орлогын 319,409.5 мянган төгрөгийн 21 мэдээллийг ил тод байршуулаагүй, гуравдугаар улирлын төсвийн гүйцэтгэлийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Коронавируст халдвар тархсантай холбоотойгоор тайлант онд Эрүүл мэндийн сайд, сангийн сайдын А/337,99 67/А/268 хамтарсан тушаалаар хоёр удаагийн журам, Эрүүл мэндийн сайдын А/605 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс 03, 04 дүгээр тоот тогтоолоор “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”, Эрүүл мэндийн сайдын А/248, А/415 тоот тушаалаар илүү цагаар ажилласны нэмэгдэл, А/496, А/585 тоот тушаалаар мөнгөн тэтгэмж олгох, А/575, А/581 тоот тушаалаар хөрөнгө гаргах, А/788 тоот тушаалаар эрх шилжүүлэх, А/803 тоот тушаалаар нэг удаагийн мөнгөн урамшуулал олгох тус тус шийдвэрийг гаргасан байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 төлбөрийн акт, 4 албан шаардлагын 5 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	366.2	3	366.2	0	0	0
Албан шаардлага	4	277927.6	4	277927.6	0	0	0
Зөвлөмж	5	24686.5	5	24686.5	0	0	0
Нийт дүн	12	302980.3	12	302980.3	0	0	0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн эсэхийг нягтлах, биелэлтийг тооцох.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 29,964.4 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 3.703.7 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 21,266.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1.115.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 5 алдаа, зөрчлийн дүн 26,260.8 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 8,388.5 мянган төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Бараа материалын 3,703.6 мянган төгрөгийн журнал бүртгэл алдаатай хөтөлсөн

4.2 Албан шаардлага

1. Тайлант хугацааны эм болон хүнсний материалын тодруулга тайланг нярвын тайлантай тулган үзэхэд нийт орлого 107,825.6, зарлага 20,151.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтын гуравт заасны дагуу НХМаягт БМ-9-өөр тайлагнаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах" гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, холбогдох хууль, тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, Албан шаардлага өгөх.

2. Тайлант онд цалинг тооцон олгохдоо НДШ, ХХОАТ-ын өглөгийг шууд, НДШ-ийг цалингийн өглөг данс руу нийт 4,994,600.00 төгрөгийн журналын бүртгэл буруу хөтөлж өглөгийн дансаар дамжуулаагүй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 5.10-т заасныг хэрэгжүүлээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож холбогдох стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу журналыг хөтөлж зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах, Албан шаардлага өгөх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд тооцооллыг тухай бүр хийгээгүйгээс 1,115.2 мянган төгрөгийн авлага нэмэгдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасныг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

2. Тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын комисс томилогдоогүй бөгөөд үндсэн хөрөнгийг 430,477.9 сая төгрөгөөр буюу үлдэх өртгөөр тооцсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 20.2.6-д заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

3. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Гуравдугаар улирлын төсвийн гүйцэтгэлийг хугацаа хоцроосон, таван сая төгрөгөөс дээж үнийн дүн бүхий 21 удаагийн 319,409.5 мянган төгрөгийн орлогын гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.4.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.4.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
				Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тэшиг сумын Эрүүл мэндийн төв	6	29,964.4	1	3.703.7	0	0	2	21,266.7	0	0	3	1.115.2